



САЙХАН-ОВОО СУМЫН
СОЁЛЫН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
Н.БАЯРМАА ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.02.13 № 01/12 ДУА-2017/105/СТА-ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Сайхан-Овоо сумын Соёлын төвийн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Төсвийн хөрөнгөөр шинэ жилийн баярын үйл ажиллагааг санхүүжүүлж, 824,000.00 /Найман зуун хорин дөрвөн мянга/ төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ Улсын Их Хурлаас баталсан “Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 47-р тогтоолын 2.5-д /төсвийн хөрөнгөөр шууд болон шууд бус хэлбэрээр шинэ жил, баяр ёслолын аливаа арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх/, заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-т /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Цаашид төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахгүй байх, төсвийн хэмнэлтийн горимд шилжсэн тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах

0000000024

2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 04 дугаар сарын 05-ны өдрийн дотор Аудитын газарт ирүүлэхийг Сайхан-Овоо сумын Соёлын төвийн эрхлэгч Н.Баярмаа, нягтлан бодогч Г.Бум-Аюуш нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:		ЗӨВШӨӨРСӨН:	
ШИИНЖЭЭЧ		ЭРХЛЭГЧ	
	Ж.УГТАХБАЯР		Н.БАЯРМАА
	НЯГТЛАН БОДОГЧ		Г.БУМ-АЮУШ

¹ Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/